



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/416

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Албан бус насан  
туршийн боловсролын төвийн  
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 1,300,000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв (Б.Гэрэлгуа)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв (Б.Гэрэлгуа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001133



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 4/416 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Гурил хөөлгөгч /хуучин/	Kangting electric, KT-RD-15A	2015	дунд	ш	1	300,000	300,000	Дэлхийн Монгол эмэгтэйчүүдийн хүмүүнлэгийн академи	Хандив
2	Шарах шүүгээ /хуучин/	DKL /EB/ XK01-102-0035	2015	дунд	ш	1	400,000	400,000		
3	Гурил зуурагч /хуучин/	Хятад, ХЦХ 25	2015	дунд	ш	1	300,000	300,000		
4	Богино долгионы зуух /хуучин/	Inventum, 700 watt	2018	дунд	ш	1	100,000	100,000		
5	Хөргөгч /хуучин/	W technology, 45 л RED-215	2013	дунд	ш	1	200,000	200,000		
							<b>1,300,000</b>	<b>1,300,000</b>		
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>										
<b>Бүртгэх хөрөнгийн дүн</b>										